

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ИНТЕГРАЦИ БА МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Н.Төмөр**

Өнөө үед дэлхийн эдийн засгийн хөгжлийн нэг гол төв болсон Ази-Номхон далайн бүс нутаг нь Зүүн хойд Ази, Зүүн-өмнөд Ази гэсэн дэд бүсүүдээс бүрдэж байна. Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутагт тухайлбал, Зүүн-хойд Азийн бүс нутагт өрнөж буй эдийн засгийн интеграцийн үйл явцад идэвхитэй орлцон, тус бүс нутгийн улс орнуудтай хоёр талын харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж байгаа билээ.

Монгол Улс Түмэн голын бүс нутгийн олон улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны асуудлыг чухалчлан үзэж, энэ бүс нутгийг хөгжүүлэхэд оролцох ажлын группийг байгуулж, “Зүүн хойд Азийн орнуудын Түмэн голын бүс нутгийн хамтын ажиллагааны тухай төлөвлөгөө”-г боловсруулан, Дорнод бүс нутгийнхаа зам тээврийн барилга байгууламжийг сайжруулж байна. Тухайлбал, төмөр зам тавих, Зүүн хойд Хятадын хилд хүрэх авто зам тавих бэлтгэлээ хийж, замын дагуух холбооны барилга байгууламжаа сэргээн засах буюу шинээр байгуулж, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа юм. Монгол-Оросын, Монгол-Хятадын хил болон Монгол-Хятад-Орос гурван улсын уулзварт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажлаа нэгэнт эхэлжээ.

Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нэг чухал хэсэг нь Түмэн голын төсөл бөгөөд Монгол Улс энэхүү төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Тухайлбал, энэ асуудлаар 1999 онд Улаанбаатарт ээлжит уулзалтыг зохион явуулав. Зүүн хойд Азийг хөгжүүлэх, ялангуяа Түмэн голын эдийн засгийн хөгжлийн бүсийг байгуулах асуудлаар БНХАУ, ОХУ, БНСУ, БНАСАУ-ын байгуулсан Зөвлөлдөх комиссын гишүүнд Монгол Улс орсон нь дээрх зорилгод нийцсэн нэг бодит алхам болсон.

Зүүн хойд Азид эдийн засгийн олон талын хамтын ажиллагааны бүс буй болгоход дөхөм үзүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр /UNDP/ 1991 онд Түмэн голын эдийн засгийн хөгжлийн бүс байгуулах төслийг боловсруулсан. Түүнд Түмэн голын билчрийн сав дахь БНХАУ-ын Хуньчуний эдийн засгийн чөлөөт бүс, БНАСАУ-ын Ражин, ОХУ-ын Владивосток, Посьет, Находка, БНСУ-ын Пусан зэрэг боомт хотуудыг хамарсан транзит худалдаа, тээвэр хийгээд олон төрлийн үйлдвэрлэлийн дэлхийн хэмжээний ач холбогдолтой том төв буй болгох зорилго дэвшүүлсэн бөгөөд эдүгээ нэгэнт хэрэгжүүлжээ. Тухайлбал, Хунчунь-Зарубино-Пусан чиглэлийн бараа тээвэрлэлтийн шугам, Хуньчунь-Ражин-Пусан чиглэлийн чингэлгийн тээврийн шугам, Хуньчунь-Посьет чиглэлийн

* Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

зорчигч бараа тээвэрлэлтийн шугам зэргийг дурдаж болно. Монгол Улсын хувьд бол ийм их ирээдүйтэй дэд бүстэй тээвэр худалдааны шууд харилцаатай болохоос гадна Ази, Европыг холбох авто замын сүлжээнд оролцох, мөн далайн тээвэр ашиглах нэмэгдэл бололцоо олдох юм.

БНХАУ Түмэн голын төсөлд идэвхитэй оролцсоор ирлээ. 1992 онд Хятадын Засгийн газар Хар мөрөн, Гирин зэрэг мужийн нутаг дэвсгэрт орших Хэйхэ, Манжуур, Суйфэньхэ, Хуньчунь зэрэг хотуудыг гадаадад нээлттэй болгосноос гадна, Төрийн Зөвлөлийн дэргэд Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэх ажлыг удирдах тусгай групп байгуулан ажиллуулав. 1996 онд “Түмэн голын бүс нутгийг хөгжүүлэх” хөтөлбөрийг БНХАУ-ын “Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 9-р таван жилийн төлөвлөгөө”-нд болон 2010 онд хэрэгжүүлэх хэтийн төлөвлөгөөнд оруулсан нь Түмэн голын төслийг хэрэгжүүлэхэд Хятадын Засгийн газар их анхаарал тавьж буйг харуулав.

2005 оны 9 дүгээр сарын 2-6-нд БНХАУ-ын Гирин мужийн Чанчунь хотод Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулган уулзалт болж, Түмэн голын бүс нутгийн хөрөнгө оруулалт, худалдааны үзэсгэлэн ажиллав. Уулзалтын үеэр Түмэн голын бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудлаар 1995 онд анх байгуулагдсан Зөвлөлдөх комиссыг дахин 10 жил сунган ажиллуулахаар Монгол Улс, БНХАУ, ОХУ, БНСУ, БНАСАУ-ын төлөөлөгчид санал нэгтэй баталжээ.

Зүүн хойд Азийн бүс нутагт эдийн засгийн хөгжлөөр тэргүүлэгч орон болох Япон Улс Түмэн голын төслийг төдийлөн сонирхохгүй байна. Энэ нь газар зүйн байршлаар Япон улс Түмэн голоос нэлээд алслагдсан, Түмэн голын бүс нутаг нь тус улсын хөрөнгө оруулалт болон худалдаа хийх гол газар биш, Түмэн голын бүс нутгийг хөгжүүлснээр Японд тийм ч их ашиг тус үзүүлэхгүй зэргээс шалтгаалсан гэж зарим мэргэжилтэн судлаачид үздэг.

Иймээс Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхийн тулд зөвхөн Түмэн голын төслийг хэрэгжүүлэхэд бус, харин тус бүс нутгийн 6 орны нийтлэг ашиг сонирхлыг тусгасан тийм төслийг боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол Улс, БНХАУ хоёр улс Зүүн хойд Азийн орнууд учраас энэ хоёр улсын эдийн засгийн хөгжил Зүүн хойд Азийн эдийн засгийн хөгжилд шууд нөлөөлөх нь дамжиггүй бөгөөд Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа нь тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд мөн чухал ач холбогдолтой. Холбогдох мэргэжилтнүүдийн тооцоолсноор, энэ бүс нутгийн хэтийн төлөв нь нэлээд урт хугацааны турш, хоёр талын хамтын ажиллагаагаар голлох юм байна.

Газар зүйн байршлаараа Монгол Улс Ази, Европыг холбосон, өөрөөр хэлбэл Зүүн-хойд Азийн улс орнуудыг Төв Ази, Баруун Ази болон Европын улсуудтай холбох чухал гүүр болно. Ази, Европыг

холбосон энэ гүүрийг сайн ашиглаж чадвал Монгол Улсын хөгжилд төдийгүй, Зүүн хойд Ази, улмаар дэлхийн эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр болох юм.

Монгол Улс өргөн уудам газар нутагтай, байгалийн нөөц баялаг ихтэй. Монгол орон төрөл бүрийн ашигт малтмалаар баян бөгөөд нүүрс, алт, зэс, гянтболд, хөнгөн цагаан, молибден, хайлуур жонш, давс, фосфор, үнэт чулуу, барилгын материалын ихээхэн нөөцтэй улс юм. Монгол Улс малын бэлчээрээр дэлхийн тэргүүний эгнээнд ордог. Монгол Улс нь хөгжлийн асар их ирээдүйтэй орон бөгөөд Зүүн хойд Азийн бүс нутгийнхаа эдийн засгийн хамтын ажиллагаанд нэлээд чухал байр эзэлдэг.

Монгол Улс бол далайд гарцгүй орон учир Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудтай тухайлбал, БНХАУ-тай эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт, мэргэжилтний болон удирдлагын туршлагыг сайтар ашиглан, дотоод бололцоогоо дайчлан, олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй оролцох нь Монгол Улсын эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэх гол хөшүүрэг болно.

Монгол Улс ба БНХАУ хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр тогтвортой хөгжиж байна. Хоёр орны өндөр түвшинд хүрсэн улс төрийн харилцааг эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаар улам баталгаажуулж байдаг бөгөөд Монгол Улс, БНХАУ-ын бүх талын харилцааг тогтвортой хөгжүүлэх явдлыг гүнзгийрүүлэхэд дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, уулзалт чухал ач холбогдолтой.

Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди 2004 оны 7 дугаар сард БНХАУ-д, БНХАУ-ын дарга Ху Жинтао 2003 оны 6 дугаар сард Монгол Улсад харилцан айлчлал хийв. Айлчлалуудын дүнгээр гаргасан Монгол, Хятадын хамтарсан мэдэгдэлд Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд сүүлийн жилүүдэд ахиц гаргасанд хоёр тал сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэв. Талууд харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, хамтын ажиллагааг олон салбар, сувгаар, төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлэхээр тохиролцов. Хоёр тал худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцов.

БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны томоохон түншүүдийн нэг бөгөөд хоёр орны эдийн засаг, гадаад худалдааны харилцаа жилээс жилд улам бүр өргөжин хөгжсөөр ирлээ. Монгол, Хятадын гадаад худалдааны хэмжээ 2001 онд 351.7 сая ам.доллар, 2002 онд 356.8 сая

ам.доллар, 2003 онд 448.2 сая ам.доллар, 2004 онд 661.3 сая ам.долларт тус тус хүрсэн нь үүнийг харуулсан нэг баримт болно. 1990 оноос Монгол Улсад гадаад орнуудаас оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ тэргүүлэх байр эзэлж, 1990-2004 оны байдлаар Хятадын 1601 компани нийт 457.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.

Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чухал салбарууд нь уул уурхайн үйлдвэр, дэд бүтцийн барилга байгууламж юм. Тухайлбал, Сүхбаатар аймгийн нутагт орших Төмөртийн овооны цайрын ордод жилд 300 мянган тн хүдэр олборлон, 70 орчим мянган тн цайрын баяжмал бэлдэх хүчин чадалтай Монгол, Хятадын хамтарсан үйлдвэр байгуулж, “Хятадын төмөр замын дөрөвдүгээр групп” ХХК Налайх-Чойрын чиглэлийн 200 км урт бүхий авто зам тавьж, энэ оны наймдугаар сард ашиглалтад тус тус оруулжээ.

Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол Улсын Дорнод бүс нутагт орших Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймгууд нь газар зүйн байршлаар чухал ач холбогдолтой байна. Энэхүү бүс нутгийн газар зүйн давуу нөхцлийг гүйцэд ашиглан хоёр тал, улмаар Зүүн хойд Ази болон дэлхийн бусад улс орнуудыг эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажилдаа оролцуулж, хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлж болох юм.

Аливаа улс орны эдийн засаг хөгжих чухал нөхцөл бол зам харилцаа юм. Иймээс Монгол Улс Дорнод бүс нутгаа хөгжүүлэхдээ, юуны өмнө зам тээврээ хөгжүүлбэл зохих бөгөөд тухайлбал, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос БНХАУ-ын ӨМӨЗО-ны Рашаант хот хүртэлх төмөр замыг ойрын хугацаанд аль болох хурдан барьж байгуулбал ашигтай. Учир нь энэ төмөр зам ашиглалтад орвол, Монгол Улсын Дорнод бүс нутаг “Түмэн гол”-ын нээлттэй бүстэй шууд холбогдоно. Ингэснээр Монгол Улс далайд гарцтай болж, гадаад хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, ашигт малтмалаа ашиглах, гадаадын жуулчдыг олноор ирүүлэх боломжийг бий болгоно. Төмөр замаа дагаад холбоо, эрчим хүч, авто замын тээвэр хурдан хөгжиж, нийгмийн асуудал ч шийдвэрлэгдэнэ.

Монгол Улс нүүрсээр нэлээд баялаг учир нүүрсээ цахилгаан эрчим хүч болгон /дулааны цахилгаан станц байгуулах/ Зүүн хойд Азийн шаардагдах орнуудад өндөр хүчдэлээр БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан хүргэх талаар судалгаа хийж болох юм. Ингэвэл Зүүн хойд Азийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд их тус болохоор барахгүй, олон хүнийг ажлын байраар хангах асуудлыг шийдэж, улмаар Монгол Улсын үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардагдах эрчим хүчийг бий болгосноор эдийн засгийн их ашигтай байх болно.

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхэд Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. L.Dondog, S.Lhagva. Mongolia: Foreign Investment, Trade and Tourism, UB.1996.
2. “Өдрийн сонин”, 2003.06.05-06., 2004.07.07-08., 2005.07.22., 08.13
3. “Business Times”, 2003.N•1 (308)
4. “Жэньминь жибао” 2003.06.06., “Жэньминь жибао” 2004.07.06
5. “Монголын уул уурхайн аж үйлдвэр 80 жилд”, УБ., 2002.
6. “Зүүн бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, УБ., 2004
7. “Erina Report” сэтгүүл, Vol.64, 2005. July
8. “Өнөөгийн Хятад” сэтгүүл, 2005.N•1
9. The Investment Forum Attracting Investment For Growth in the Greater Tumen Region (Changchun, 2-6 Sep, 2005)
10. “Новости Монголии” N•41, 14 Октября 2005 года